

КАНАД:

ГРЭСИ НАЙРОВЫН ЗАЛУУС

БИД АХИН ХҮЛЭЭХГҮЙ

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ 



ГРЭСИ НАЙРОВЫН ЗАЛУУС

КАНАД

13 настай Жиане Төртэл нь Канадын Онтарио мужийн Грэси Найровын Анишинабэ уугуул иргэн. Сайхан ирээдүйн төлөөх нутгийн залуусын тэмцлийн үеэр тэр “засгийн газар ярьсаар байгаа ч юу ч хийхгүй байна” хэмээн хэлжээ.

Тус улсын Засгийн газар 1960-аад онд хавтангийн үйлдвэрт 10 тонн хаягдлаа гол руу хаяхыг зөвшөөрсний улмаас Найровын оршин суугчид мөнгөн усанд гүн хордсон. Үүний хор уршиг өнөөдөр ч хэвээр байгаа юм.

Загасчлах нь эдгээр уугуул иргэдийн амьдралын чухал хэсэг. Гэвч 50 гаруй жилийн турш мөнгөн ус голын загасыг хордуулж, идэхэд аюултай болсон. Энэ нь Грэси Найровийн оршин суугчдын эрүүл мэндийг хохироогоод зогсохгүй, соёл, уламжлалыг нь устгаж байна.

Канадын Засгийн газар 2017 онд энэ хямралыг “нэг мөр дуусгавар болгоно” хэмээн амлалт өгсөн. Үүнд гол мөрөнг цэвэрлэх, эрүүл мэндийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нутгийн иргэдэд нөхөн олговор олгох шаардлагатай байгаа юм. Гэвч уугуул иргэдийн эрүүл мэндэд нүүрлээд буй энэ аюулын эсрэг дорвитой арга хэмжээ аваагүй хэвээр байсаар байна.

Грэси Найровын залуус засгийн газар өгсөн амлалтаа биелүүлэх хүртэл тэмцлээ үргэлжлүүлнэ гэсэн юм. Канад улс Грэси Найровын оршин суугчдад мөнгөн уснаас болж алдсан бүхнээ эргүүлэн авахад туслах ёстой.

КАНАДЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭЕ.

Канад улсын эрх баригчдаас Грэси Найровчуудын мөнгөн уснаас болж алдсан бүхнийг нь буцааж сэргээхэд тулахыг шаардацгаая.

*Prime Minister of Canada
80 Wellington Street
Ottawa, Ontario K1A 0A2
Salutation: Dear Prime
Minister*

ГРЭСИ НАЙРОВЫН ЗАЛУУСТ ДЭМЖИЖ БУЙГАА ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Эв санааны нэгдлээ илэрхийлсэн захидлаа дараах жишээгээр өөрийн цахим хаягтаа нийтлээрэй: “Support from [insert your country] for the youth of Grassy Narrows. It’s time for #mercuryjustice – #freegrassy”.

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭЕ**

December 2019
Index: AMR 20/0749/2019 English
Images: cover: © Allan Lissner (Main image)
© Jon Schledewitz (CC)
Back page: © Amnesty International